

“ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ”-Г
2025 ОНД САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ		Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.	Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр	Албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод эсэхэд дүн шинжилгээ хийж, дутуу мэдээллүүдийг байршуулах;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллүүдийг ил тод байршуулсан байна.	Газрын даргын 2025 оны А/243 дүгээр тушаалаар төрийн байгууллагын нэгдсэн www.gov.mn , www.shilen.gov.mn , www.namem.gov.mn цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх бүхий ажилтан, хяналт тавих нэгж, асуудал бүрээр мэдээлэл оруулах ажилтан зэргийг нарийвчлан зааж баталсан. www.gov.mn , www.shilen.gov.mn , www.namem.gov.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны талаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллүүдийг хугацаанд нь байршуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мөн баталсан. Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байршуулсан. Цаг уур, орчны шинжилгээний газрын “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилт 2023 онд 93,7%-тай үнэлэгдэж байсан бол 2024 онд мэдээлэл огт оруулаагүй 0%-тай, 2025 оны 1 дүгээр улиралд 0%, 2 дугаар улиралд 73.6%, 3 дугаар улиралд 43.3%-тай дүгнэгдсэнтэй холбогдуулан газрын хурлаар тушаалын хэрэгжилт, бодит нөхцөл байдлыг нэг бүрчлэн тулган хэлэлцэж, 2025 оны 12 дугаар сард бүрэн оруулах үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллав.	100%

2.	Байгууллагаас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд түгээх, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах;	- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3-аас доошгүй удаа тухайн байгууллагын талаар мэдээлэл гарсан байх; - 2-оос доошгүй удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байх;	OWL- 9 дүгээр сарын 01-нээс OWL буюу "Overnight Weather Lookout" программыг цаг уурын 3 өртөөнд туршилтаар нэвтрүүлэхэд бэлэн боллоо. Энэхүү программ нь цаг уурчдын шөнийн 23:00, 02:00, 05:00 цагийн ажиглалтын мэдээг автоматаар коодлон дамжуулах бөгөөд ажиллагсдын шөнийн ачааллыг бууруулах, эрүүл мэндийг хамгаалах ач холбогдолтой. (Зураг 1) D-LAB Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори үйл ажиллагаандаа D-LAB цахим бүртгэл, мэдээллийн системийг нэвтрүүллээ. Агаар, ус, хөрсний чанарын шинжилгээ хийлгэх, багаж шалгуулах, баталгаажуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа энэ үед төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад дэвшил гарч байна. (Зураг 2) Цаг уур, орчны шинжилгээний газар цаг агаарын тодорхойлолт, ажиглалтын мэдээ авах процессыг цахимжуулж, хэрэглэгч өөрийн сонгосон үзүүлэлт, хугацаа, нөхцөлөөр авах боломжийг бүрдүүллээ. Мөн НӨАТ-ийн баримт, мэдээ баталгаажуулалтын хуудсыг цахимаар авах боломжтой болж байна. Ус цаг уур, орчны мэдээллийн төрөлжсөн архиваас төсөл хэрэгжүүлэгчид, байгаль орчны үнэлгээний компаниудын ТЭЗҮ, тайлан боловсруулахдаа авч ашигладаг эх мэдээ, даатгал, онцгой, хуулийн байгууллагуудын авдаг лавлагаа албан бичгээр ирж, цаасан суурьтай хариу өгдөг байдал өөрчлөгдлөө. Энэхүү үйлчилгээг www.weather.gov.mn цахим хуудаснаас болон И-Монголиагаар дамжуулан авах боломжтой. Хугацаа хэмнэгдэж, чирэгдэл арилж байна. (Зураг 3, 4) Цаг уур, орчны шинжилгээний салбарын үйл ажиллагааны талаар 2025 онд 200 удаа текстэн мэдээ (зурагтай), 42 удаа видео мэдээ бэлтгэж, давхардсан тоогоор 50-60 удаагийн мэдээг мэдээллийн цахим сайтууд болон MNB, Ийгл, Тэнгэр, Монгол, ТВ8, Малчин зэрэг телевизийн мэдээгээр хүргэсэн.	100%
----	--	--	---	------

				“И-Монгол академи”-тай хамтран аппликейшний мэдэгдэл хүргэх системээр цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээллийг шуурхай хүргэж эхэлсэн. (Зураг 5) Мэдээний API нээлттэй болгож, 16 цахим хуудсанд хүргүүлсэн. Үндэсний цаг уурын байгууллагын мэдээгээ гаргадаг болсон. Агаарын бохирдлын мэдээг ажлын өдөр бүр постероор олон нийтэд мэдээлж байна. ДДЭШ тв ххк-тай цаг агаарын мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх талаар хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулан дэвшилтэт 3.0 төхөөрөмж дээр суурилан ЦУОШГ-аас гаргаж буй цаг агаарын өдөр тутмын болон аюултай, гамшигт үзэгдлийг мэдээллийг шуурхай хүргэх юм. Тус шинэ төхөөрөмжийн “ЦАГ АГААР” цэсээс монгол орны хаанаас ч 21 аймаг, 330 сумын цаг агаарын мэдээллийг харах боломжтой болсон. (Зураг 6) Цаг уурын байгууллагын үйл ажиллагаа сурталчлах нээлттэй өдөрлөгийг явуулах чиглэлийг хүргүүлсний дагуу 21 аймагт, их дээд сургууль, дунд сургуулиудад мэргэжил сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж 3414 сурагч, оюутан, иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан. (Зураг 7, 8, 9) Д.Сүхбаатарын талбайд БНСУ-ын 7 хоног нээлттэй хаалганы өдрөөр БНСУ-ын Кесо байгууллагатай хамтран “Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд агаарын чанарын станц суурилуулах” төсөл, төслийн явц, агаарын чанарыг хэмждэг багаж тоног төхөөрөмж, агаарын бохирдлоос өөрийгөө хэрхэн сэргийлж, хамгаалах, агаарын чанарын индекс болон агаар.mn цахим сайтын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчилж, танилцуулга, мэдээллийг тараасан. ЦУОШГ-аас хариуцдаг eic.mn, iss.mn зэрэг үндсэн 23 сангаас 20 дэд санд 2025 оны мэдээ бүрдүүлэлтийн ажлыг холбогдох төрийн байгууллагууд, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүдийн 114000 гаруй мэдээгээр баяжуулалт хийгдсэн.	
--	--	--	--	--	--

				Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төв, орон нутгийн байгууллагуудын цаг үеийн мэдээлэл, гадаад дотоод хамтын ажиллагаа, хурал, сургалт зэрэг мэдээ, мэдээллийг салбарын нийт хамт олонд хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор “Дотоод мэдээлэл солилцооны платформ”-ийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглаж эхэллээ. Энэхүү системийг ашиглаж эхэлснээр төв орон нутгийн байгууллагуудын ялангуяа өртөө, харуулуудын хоорондын харилцаа холбоо сайжрах, харилцан туршлага судлах зэрэг олон давуу тал бий болсон. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт Монгол Улсын үндэсний MNS стандарт 189, олон улсын ISO стандарт 179, нийт 368 стандарт мөрдөгдөж байна. ЦУОШГ-ын Ажлын хэсэг дээрх стандартуудад техникийн түвшний үзлэг хийхэд дахин хянаж, шинэчлэх шаардлагатай 8, шинээр боловсруулж, батлуулах 11, нэр томьёо хуулийн нэр томьёотой зөрчилдсөн, шинжилгээний аргын мэдрэх чадвар муу, хэт хуучирсан арга, аргачлал бүхий хүчингүй болгох 9 стандарт байгааг тогтоосон. Стандартуудыг шинээр боловсруулах, дахин хянаж, шинэчлэх хэрэгцээ шаардлага болон хүчингүй болгох үндэслэлийг тодорхойлж, 2026 оны стандартын төлөвлөгөөнд тусгуулах саналаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад ЦУОШГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/819 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	
3.		Олны танил хүмүүсээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлуулсан бичлэг, сэтгэгдэл, пост мэдээлэл цахим орчинд оруулах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;	- Олны танил 3-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгааг хийлгэсэн байх;	Цаг агаарын текстэн мэдээг хүргэхдээ байгалийн гэрэл зургийн мастер Erdenebulgan Photography-ын бүтээлүүдийг өөрийнх нь зөвшөөрөлтэйгөөр суурь болгон ашиглаж эхэллээ. Шилдэг зургуудыг нь түүний хуудаснаас гадна Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл хуудсаар дамжуулан үзэх боломжтой болсон. (Зураг 10) Мэргэжлийн байгууллагын хувьд маркетингийн гэхээс илүү бодитой байхад анхаарч цаг агаарын мэдээг боловсруулсан цаг уурч, синоптик инженерүүдээр нь тайлбарлуулахаар зорьж байна. (Зураг 11)	100%

				НҮБ-аас Олон Улсын Авлигын эсрэг өдөр болгон зарласан 12 дугаар сарын 09-ний өдөр түгээхээр Авлигын эсрэг Залуустай хамт Шударга маргаашийг бүтээе! гэсэн уриатай видео контентыг бүтээсэн байна.	
4.		Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахыг хориглох, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах;	- Бүх албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх; - Албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх;	Салбарын нийт 26 байгууллагын хэмжээнд ёс зүйн алдаа гаргасан 34 хаагчид сахилгын шийтгэл ноогдуулсан. Манай байгууллагын Ёс зүйн дэд хорооноос Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд: 1. 2025 оны 2 дүгээр сарын 18-ны өдөр Монгол улсын Ёс зүйн хорооны гишүүн М.Цэрэнбатыг урьж “Төрийн албан хаагчийн ёс зүй 2. Ёс зүйн хорооны Гомдол мэдээлэл хариуцсан референт Д.Мөнхбат “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, шийдвэр” 3. Ёс зүйн дэд хорооны Дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болорзул “ Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” 4. СЭМҮТ-ийн Сэтгэцийн тэргүүлэх зэргийн эмч, Ёс зүйн хорооны дарга З.Цэндсүрэнг урьж “Сэтгэцийн эрүүл мэнд ба Ёс зүй, стресс менежмент” зэрэг сургалтуудад албан хаагчдаа тус тус хамрууллаа. (Зураг 12) Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар тушаалаар Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Халиун, Баянтоорой, Цээл, Алтай, Ховд аймгийн Булган, Үенч, Алтай сумдад 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 4 дүгээр сарын 02-ны өдрүүдэд ажиллаж, төрийн байгууллагын үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй талаар, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцах, хяналт шалгалт хийж, Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянан шалгаж, Төрийн	100%

				албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслаж ажилласан. Тус газрын ёс зүйн дэд хороо өөрийн цахим хуудсыг ЦУОШГ Ёс зүйн дэд хороо нээн цахимаар өргөдөл, гомдол хүлээн авч байна.	
5.		Тухайн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;	-Дүн шинжилгээ, ажлын байрны зураглал хийсэн байх; - Үр дүнгээс хамааран хүнд суртал, чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байх;	ЦУОШГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/307 дугаар тушаалаар ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээний хүртээмжийн одоогийн байдалд үнэлгээ хийсэн. Үнэлгээний тайланг хавсаргав.Тус агентлаг нь иргэдээс цахим шуудан info@namem.gov.mn/, цаасаар, биечлэн болон Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээж авдаг. Агентлагт ирсэн өргөдөл гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэдэг ба байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журамдаа тусгаж иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг ажлын өдөрт нь багтаан шийдвэрлэдэг болох зорилт тавьж хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн иргэд цаг агаарын тодорхойлолт, ажиглалтын мэдээ авах процессыг цахимжуулж Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ И-Монголиа, archive.weather.gov.mn-ээр дамжуулан хэрэглэгч өөрийн сонгосон үзүүлэлт, хугацаа, нөхцөлөөр мэдээ авах боломжийг бүрдүүлсэн ба НӨАТ-ийн баримт, мэдээ баталгаажуулалтын хуудсыг цахимаар авах боломжтой болсон. Тухайлбал 4 дүгээр улиралд Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан 3 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд үүнийг хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн болно.	100%

6.		Тухайн байгууллагын албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;	-Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	Цаг уур, орчны шинжилгээний газар болон харьяа байгууллагуудын албан хаагчдад АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Г.Ариунзаяа 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр “Авлига, түүний шалтгаан нөхцөл, хор хөнөөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдвээр 40 минут мэдээлэл өгч, сургалтын дараах албан хаагчдын сонирхсон асуултад хариулт өгсөн. (Зураг 13)	100%
7.	Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр	Авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг удирдлагын зүгээс хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ нийт албан хаагчдад илэрхийлэх;	- Авлигын зөрчлийн талаар мэдээлэл өгөх сувгуудыг сурталчилсан байх; - Мэдээ, мэдээллийн мөрөөр хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, буруутай албан хаагчдад хариуцлага тооцсон байх;	Авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг байгууллагын вэб сайт болон тусгай самбарт түгээж сурталчилсан байна. Удирдлагын зүгээс дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ агентлагийн даргын зүгээс удаа дараа илэрхийлэхийн зэрэгцээ 7 хоног бүрийн Даваа гаригт удирдах ажилтны шуурхай, сар нийт хамт олны өргөтгөсөн хурлыг хийж, асуулт, хариулт, тулгамдсан асуудлын шийдлийг нээлттэй хэлэлцдэг болсон. БОУАӨСайдын 2025 оны А/458 дугаар тушаалаар тус газрын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдөж Хяналт, дотоод аудитын хэлтсийг байгуулсан 2025 оны 06 дугаар сараас хойш удирдлагын үүрэг чиглэл, албан хаагчдын өргөдөл гомдлын дагуу нийт 4 удаа төлөвлөгөөт бус дотоод аудит, 7 өргөдөл, гомдлыг хянан шалгаж дараах үр дүнг гаргасан. Үүнд: 1. “Уур амьсгал, хөдөө аж ахуйн цаг уурын хэмжих хэрэгсэл, сэлбэг материал” нийлүүлэх /ЦУОШГ/20250601020/ дугаартай тендерийн гүйцэтгэгчээр шалгарсан “Гэрэгэ дижитал технологи” ХХК-ний нийлүүлсэн 3 төрлийн нийт 18 хэмжих хэрэгслүүд шаардлага хангахгүй, буцаагдсан асуудалд хяналт шалгалт хийсэн танилцуулга, дүгнэлтийн дагуу газрын 2 албан хаагч, харьяа байгууллагын 2 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар	

			зүйлийн 48.1 дэх хэсэгт заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулсан. 2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.3.-д заасны дагуу үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавихад “Төв, орон нутгийн интернэтийн үйлчилгээ” ЦУОШГ/20250103001 дугаар бүхий тендерийн үнэлгээний хорооны нийт гишүүдийн 100 хувийн саналаар шалгаруулсан “ЭС АЙ СИ ТИ” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмжид дотоод хяналт хийж, хууль тогтоомжид нийцэхгүй байгааг илрүүлж зөвлөмжийг буцаасан. 3. Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3-т “шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно”, 109.8-д “Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно” заалтыг хэрэгжүүлээгүй, ЦУОШГ-ын даргын тушаал шийдвэргүйгээр шөнийн ээлжийн 22 албан хаагчдад шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг 0.3 хувиар тооцож байсан алдааг илрүүлж, 2025 оны дутуу олгосон 30,631,733 төгрөгийн нэмэгдэл цалин хөлсийг нөхөж олгох шийдвэр гарсан. 4. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 2.2.1.12-д заасны дагуу Ус цаг уурын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж иргэд, аж ахуйн нэгж, албан хаагчдаас хандивын орлого, зарлагын дэлгэрэнгүй тайланг ЦУОШГ-ын шилэн данс https://shilendans.gov.mn/, байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдал https://namem.gov.mn/ байршуулах зөвлөмж өгсөн. (Зураг 14, 15)	
--	--	--	--	--

8.		Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулах арга хэмжээ авах, санал асуулгын үр дүнд үндэслэн Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авах;	-Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх; - АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байх;	ЦУОШГ-ын удирдах албан тушаалтнуудын удирдлагын хандлага, ёс зүй, удирдлагын ур чадварын үнэлгээг нийт албан хаагчдаас цахимаар авч үнэлсэн. Үүний мөрөөр агентлагийн даргаас хэлтсийн дарга нарт тус бүрд нь үнэлгээг танилцуулж, анхаарах, сайжруулах, ур чадваруудын талаар үүрэг чиглэл өгсөн. АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд харьяа байгууллагууддаа 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 01/610, 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/771, 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/883 дугаартай зөвлөмж, албан бичгүүдийг хүргүүлэн ажиллаж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах ажлын хүрээнд ЦУОШГ-аас 2 хэлтсийн дарга, харьяа 2 аймгийн УЦУОШТөвийн даргад сахилгын шийтгэлийн арга хэмжээг авч 4 аймгийн УЦУОШТөвийн даргын зөрчлийг хянуулахаар АТГ-ын Хяналт шалтгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.	100%
9.	Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах чиглэлээр	Байгууллагын удирдах албан тушаалтан нийт хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан хаагчдаас гарсан авлигын эсрэг санал санаачилгыг дэмжин ажиллах	-Нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан байх;	Салбарын хэмжээнд ажиллаж байгаа Нийтийн албан тушаалтнуудад 11 дүгээр сарын 20-ны өдөр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” цахим сургалт, Хяналт шалтгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран “Мэдэгдэл, тайлбарыг ямар үед гаргах, хамаарал бүхий этгээддээ захиргааны шийдвэр гаргасан тохиолдолд хуулийн ямар арга хэмжээ авагдах вэ” сэдэвт цахим сургалтуудыг зохион байгуулж нийт 104 албан хаагч хамрагдсан. Мөн байгууллагын “Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог хангах нь” төлөвлөгөөг батлуулан тусгагдсан үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%



(Зураг 1)

D-LAB

ЦАХИМ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн үйл ажиллагаанд D-LAB цахим бүртгэл, мэдээллийн систем нэвтэрлээ.

- <https://lab.weather.gov.mn/> хаягаар захиалагч хүсэлтээ өгнө.
- Хүсэлтийн явцыг хянах боломж.
- Шинжилгээний дүнд үзүүлэх субъектив нөлөө багасна.

СОРЬЦ
 Агаар
 Ус
 Хөрс


БАГАЖ
 Чийг
 Температур
 Даралт

Төлбөр төлөх боломжууд
 Q-ruy Карт Цахим нэхэмжлэх


(Зураг 2)




(Зураг 3)



(Зураг 4)



(Зураг5)



(Зураг 6)




(Зураг 7)




(Зураг 8)




(Зураг 9)




(Зураг 10)



(Зураг 11)



(Зураг 12)



(Зураг 13)



(Зураг 14)



(Зураг 15)

...000...